



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/160

Мандалговь

Тэнгэрлэг гэр бүл алдаршуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын а, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тугаалаар батлан гаргасан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2010 оны А/526 тоот захирамжаар батлагдсан “Тэнгэрлэг гэр бүл шалгаруулах журам”-ын 5.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гэр бүлийн уламжлалт зан заншлыг залуу хойч үеийнхэндээ үлгэрлэн уламжлуулах, нэр хүндтэй гэр бүлийг алдаршуулах зорилгоор 2017 оны аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-ээр дараах гэр бүлүүдийг шалгаруулж, алдар цол олгосугай. Үүнд:


1. “Оюунлаг гэр бүл”-ээр Говь-Угтаал сумын иргэн Цэндийн Төмөрбаатарын гэр бүл
2. “Авьяаслаг гэр бүл”-ээр Дэлгэрцогт сумын иргэн Лувсанчимэдийн Баасангийн гэр бүл
3. “Бүтээлч гэр бүл”-ээр Адаацаг сумын иргэн Гончигдоржийн Цогнэмэхийн гэр бүл
4. “Спортын алдартан гэр бүл”-ээр Сайнцагаан сумын иргэн Төмөрбатын Эрдэнэсүхийн гэр бүл
5. “Өнөр гэр бүл”-ээр Гурвансайхан сумын иргэн Базарын Алтангэрэлийн гэр бүл

Хоёр. “Тэнгэрлэг гэр бүл”-үүдийг алдаршуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Шалгарсан гэр бүлүүдийг алдаршуулах ёслолын үйл ажиллагааны зардалд 315.000 /гурван зуун арван таван мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



023000518